

УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД

2025.02.08

Улаанбаатар хот

Хяналтын журмаар гомдол гаргах нь

Гомдол гаргагч: Гуравдагч этгээд “Соёмбо буудай” ХХК-ийн өмгөөлөгч: Г.Мөнхбуян
 Хааг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж, Центрум 201 тоот
 Утас: 99797898

Хэнтий аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 10 сарын 24-ны өдрийн 127/ШШ2024/0013 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 01 сарын 07-ны өдрийн 221/МА2025/0018 дугаар магадлалын зарим хэсгийг эс зөвшөөрч Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.2, 123.2.3, 123.2.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн гуравдагч этгээдийн өмгөөлөгчийн зүгээс дараах гомдлыг гаргаж байна. Үүнд:

НЭГ: Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн:

Нэхэмжлэлийн шаардлага үндэслэлийн тухайд:

1.1 Нэхэмжлэгч “Буйр нуур, Халхгол нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага” нь шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлагаа дараах хоёр үндэслэлээр шүүхэд эцсийн байдлаар тодорхойлсон болно.

1. Соёмбо буудай ХХК-д 2013 онд олгогдсон газар эзэмших эрхийн гэрчилгээг цуцлахгүй байгаа эс үйлдэхгүйг хууль бус болохыг тогтоож, хүчингүй болгохыг даалгах
2. Халхгол сумын засаг даргын 2022 оны 05 сарын 11-ны өдрийн А/73 дугаар захирамжийг хүчингүй болгуулах

Нэхэмжлэлийн үндэслэлээ:

- Соёмбо буудай ХХК нь Өвөр Монгол эзэнтэй гэгдэх Н.Цэвэлмаа захиралтай “Ашид арвижих үндэс” ХХК-ийн охин компани болгон өөрчилж Газрын тухай хууль зөрчсөн,
- БНХАУ-ийн иргэн Лю Ай Минн, Вен Тао нараас хөрөнгө оруулах нэрийдлээр Дорнод дэ юу органик хөдөө аж ахуй ХХК-д 100 хувь ашиглуулах, газрын тухай хууль тогтоомж зөрчсөн
- Ашиглах зөвшөөрөлгүй химийн бодис бордоог ашиглаж, үр тарианы аж ахуй нэгжид хориглох хөрс боловсруулах технологийг зөрчсөн
- Эзэмшил газраа хуульд заасны дагуу зориулалтын дагуу 2-оос дээш жил үйл ажиллагаа явуулаагүй, тариалалт эрхлээгүй үйл баримт тогтоогдсон гэж

Харин шүүх хуралдааны хэлэлцүүлгийн явцад нэхэмжлэлийн үндэслэлээ Газрын тухай хуулийн 40.1.2, 40.1.4, 40.1.6 дахь хэсэгт заасныг зөрчсөн гэж тайлбарласан.

1.1 Шүүх хэрэг маргааныг шийдвэрлэхдээ нэхэмжлэгчийн маргаагүй үндэслэлээр хэргийг шийдвэрлэсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил болсон байдаг. Тодруулбал:

Анхан шатны шүүхийн шийдвэрийн Үндэслэх нь хэсэгт: “Нэхэмжлэгчээс Соёмбо буудай ХХК нь Химийн хортой бодис ашигласан, 3 жил дараалан 2016-2019 онд газартаа тариалалт хийгээгүй гэж маргасан ч, энэ нь 2022 оны 05 сарын 30-ны өдрийн Шинжээчийн дүгнэлт, мөн 2023 оны 07 сарын 03-ны өдрийн 04 дугаартай Шинжээчийн дүгнэлт, 2023 оны хийсэн Газрын төлөв байдал чанарын хянан баталгааны Хөрсний химийн ахуйн бусад бохирдол байхгүй дүгнэлтээр няцаагдаж байна. Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2, 40.1.4, 40.1.6-д заасан үндэслэл тогтоогдохгүй байна (шийдвэрийн 14, 15 дугаар хуудас)” гэж дүгнэсэн.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь Шүүхийн өмнө эрх тэгш байх, Мэтгэлцэх зарчимд үндэслэн явагддаг бөгөөд дээрх шүүхийн шийдвэр, магадлал нь Захиргааны

хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйл 6.3 дахь хэсэгт заасан “Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч хэргийн үйл баримт, хэргийн оролцогчийн буруутай үйл ажиллагаа, хууль зүйн үндэслэл, хууль хэрэглээний талаар нотлох болон үгүйсгэх байдлаар мэтгэлцэнэ” гэж заасныг зөрчсөн. Тодруулбал нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлага үндэслэлд дурдсан дээрх тайлбарыг хариуцагч болон гуравдагч этгээдийн өмгөөлөгчийн зүгээс бүхэлд нь үйл баримт, хууль хэрэглээний хувьд няцаасан бөгөөд шүүх тухайн нөхцөл байдлыг харгалзан үзэж “нэхэмжлэгчийн нэхэмжлэлд дурдсан үндэслэл тогтоогдохгүй байна” хэмээн шийдвэрийн 15 дугаар хуудсанд дүгнэсэн байдаг.

Гэсэн атлаа шүүхийн зүгээс талуудын мэтгэлцээгүй үндэслэлээр дүгнэлт гаргаж Газрын тухай хуулийн 40.1.1 дэх хэсэгт заасан “хууль тогтоомжийг удаа дараа зөрчсөн ” гэж нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэж байгаа нь талуудын эрх тэгш мэтгэлцэх зарчмыг зөрчсөн үйлдэл гэж үзэж байна. Мөн дээрх дүгнэлт нь шүүхээс хариуцагч, гуравдагч этгээдийн мэтгэлцээний туршид хийсэн хууль зүйн үндэслэл бүхий тайлбар, татгалзлын үндэслэл болсон үйл баримт (Захиргааны хэрэг үүссэн цагаас эхлэн цуглуулсан нотлох баримт), зэргийг нотолгооны ач холбогдолгүй болгож байгаа бөгөөд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйл 106.5 дахь хэсэгт заасан “Шүүх нэхэмжлэлийн шаардлагын хүрэнгээс хэтэрсэн болон хэргийн оролцогчдын маргаагүй исцүлдээр дүгнэлт хийж, шийдвэр гаргаж болохгүй” гэж заасныг ноцтой зөрчиж хэргийг шийдвэрлэсэн нь илтэд үндэслэлгүй байна.

Гуравдагч этгээдийн зүгээс давж заалдах гомдол энэ тухай дурдсан боловч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх энэ хэсэгт дүгнэлт хийлгүйгээр анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил төдийгүй Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.4 дэх хэсэгт “Үндэслэх хэсэгт хэрэгт байгаа болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, хэргийг хянан шийдвэрлэхэд үндэслэл болгосон нотлох баримтыг үнэлж дүгнэсэн байдал, захиргааны актын хууль зүйн үндэслэл, түүнд өгөх тайлбар, шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон хэм хэмжээ, тэдгээрийг хэргийн бодит нөхцөл байдлад хэрхэн тайлбарлаж хэрэглэсэн тухайгаа тусгана” гэж заасныг зөрчсөн.

1.2 Шүүхийн шийдвэрийн Үндэслэх нь хэсэгт “Гуравдагч этгээд Соёмбо буудай ХХК нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээгүй нь Дорнод аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газрын 2021 оны 06 сарын 03-ны өдрийн 217 дугаарт албан бичиг, 2014 оны 10 сарын 17-ны өдрийн Дорнод аймгийн мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн зөвлөмжийн шлэрсэн албан зөрчил дутагдал гэх баримтуудаар тогтоогдож байх бөгөөд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3-т заасныг хэрэгжүүлээгүй” гэж дүгнэсэн байдаг.

Харин Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Хянавал хэсгийн 6.2 дахь хэсэгт “Гуравдагч этгээд Соёмбо буудай ХХК нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээгүй болох нь хэрэгт авагдсан Дорнод аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газрын 2021 оны 06 сарын 03-ны өдрийн 217 дугаарт албан бичиг, 2014 оны 10 сарын 17-ны өдрийн Дорнод аймгийн мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн Зөвлөмж, хэргийн оролцогчийн тайлбараар тус тус тогтоогдож байна” хэмээн дүгнэсэн байдаг.

Гэвч дээр дурдсанчлан нэхэмжлэгчийн зүгээс Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгээгүй гэх үндэслэлээр маргаагүй тул гуравдагч этгээдийн зүгээс энэ талаар холбогдох баримтыг шүүхэд гаргаж өгөөгүй болно. Түүнчлэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт “Хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах үүргийг захиргааны хэргийн шүүх гүйцэтгэнэ” гэж заасан бөгөөд шүүхээс энэ талаар нотлох баримт цуглуулах ажиллагааг хангалттай хийгээгүй.

Тодруулбал Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт “Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийнэ” гэж заасан бөгөөд анх энэхүү

маргаан бүхий газрыг Дорнод аймгийн Халхгол сумын засаг даргын 2012 оны 10 сарын 16-ны өдрийн А/80 дугаар захирамжаар “Жи Эм Эс Эс” ХХК-д газар тариалалтын зориулалт бүхий 1631.2 м.кв газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр эрх олгосон бөгөөд манай компани тухайн газрыг дээрх компаниас шилжүүлж авсан байдаг. Иймээс “Жи Эм Эс Эс” ХХК нь газар тариалалтын төсөл хэрэгжүүлэхээс өмнө Байгаль орчинд нөлөөлөх ерөнхий үнэлгээ хийлгэсэн байх боломжтой юм.

Түүнчлэн Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.7 дахь хэсэгт “Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар эзэмшилд олгож байгаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээг тухайн газар эзэмших гэрээний хавсралт болгоно” гэж заасан бөгөөд шүүхээс маргаан бүхий газрыг эзэмших гэрээ түүний хавсралт баримтыг цуглуулалгүйгээр Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээгүй хэмээн дүгнэж хэргийг шийдвэрлэсэн нь илтэд үндэслэлгүй байна.

-Учир нь Дорнод аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2021.06.03-ны өдрийн 2/7 дугаар албан бичигт “... Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасны дагуу Мэргэжлийн хяналтын газраас мэдээлэл авна уу” гэх агуулга бүхий албан бичиг ирүүлсэн бөгөөд шүүхээс энэ талаар дахин тодруулах нотлон баримт цуглуулах ажиллагаа хийгээгүй.

-Түүнчлэн хариуцагч Халхгол сумын засаг дарга шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа (хурлын тэмдэглэлийн 13 дугаар тал) Шүүгч Б.Баярмаа: “Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгээж байсан уу? гэхэд”

-Хариуцагч: “Өмнө нь боонд нь хийлгээж байсан гэв” гэж хариулсан байхад “хариуцагч тайлбартаа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээж байгаагүй” гэх байдлаар дүгнэлт гаргаж байгаа нь үндэслэлгүй бөгөөд нотлох баримтыг үнэн зөв эргэлзээгүй талаас нь үнэлж дүгнэж чадаагүй байна.

-Мөн Соёмбо буудай ХХК-ын зүгээс Дорнод аймгийн мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2014 оны 10 сарын 17-ны өдрийн 12-02-018/85 тоот Зөвлөмжид заасныг үндэслэн 2017 оны 08 сарын 06-ны өдөр “Нарт шүүн консалтинг” ХХК-наар үнэлгээ хийлгэсэн байдаг боловч шүүхээс энэхүү үйл баримтыг хэрхэн үнэлж буй талаар тодорхой дурдаагүй буюу ЗХШХШТХ-ын 34 дүгээр зүйл 34.1, 34.2 дахь хэсгийг тус тус зөрчсөн, энэ талаар тодруулах ажиллагаа хийлгээгүйгээр хэргийг шийдвэрлэж буй нь шүүх нотлох баримт цуглуулах үүргээ бүрэн биелүүлэлгүй хэргийг шийдвэрлэх Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.2 дахь хэсэгт заасан “Шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх” зарчмыг зөрчсөн гэж үзэхээр байна.

ХОЁР: Хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн тухайд:

2.1 Хэнтийн аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 10 сарын 24-ны өдрийн 127/ШШ2024/0013 дугаар шийдвэрийн Үндэслэх нь хэсэгт “Харин Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйл 40.1.1-д заасан “эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын тухай хууль тогтоомж, ... удаа дараа ... зөрчсөн” нь гуравдагч этгээд нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасныг 2013, 2022 онд тус тус зөрчиж Байгаль орчны нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгээгүй байхад хариуцагч 2013 оны А/113 дугаар захирамжаар газрыг тариалангийн зориулалтаар эзэмшүүлэн, улмаар үргэлжлүүлэн 2022 оны А/73 дугаартай захирамжаар уг газрыг 4 нэгж талбар болгон хуваан эзэмшүүлсэн нь Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, 34.7-д заасныг зөрчсөн нь тогтоодгож байх тул Дорнод аймгийн Халхгол сумын Засаг даргын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн А/73 дугаартай захирамжийг хүчингүй болгох нь зүйтэй гэж үзлээ” хэмээн дүгнэсэн бол Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хэргийг бүхэлд нь хянанс гэх боловч энэ талаар дүгнэлт хийгээгүй.

Улсын дээд шүүхийн 2008 оны “Газрын тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай” 15 дугаар тайлбарын 1.9 дэх хэсэгт “Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1-д заасан “... удаа дараа ...” гэдгийг мөн зүйлийн 40.1.2-40.1.6-д зааснаас бусад хэлбэрээр хууль тогтоомж,

гэрээний нөхцөл, болзлыг 2 буюу түүнээс дээш удаа зөрчсөн байхыг ойлгоно, Нэг зөрчлийг давтан эсхүл өөр өөр зөрчил гаргасны аль аль нь дээрх ойлголтод хамаарна, Мөн зүйл, хэсэгт заасан "... **поцтой зөрчил...**"-ийг газар эзэмшүүлэх гэрээний талууд гэрээний нөхцөл, болзлын онцлогтой холбогдуулан харилцан тохиролцон тогтоож, уг зөрчлийн тохиолдол бүрийг гэрээнд нэрлэн заасан байвал зохинно" гэж тайлбарласан байдаг. Өөрөөр хэлбэл шийдвэрийн хууль зүйн үндэслэлд энэхүү заалтыг хэрэглэн тайлбарлаж байгаа нь газрын хууль тогтоомж, гэрээний заалтыг 2 буюу түүнээс дээш удаа зөрчсөн болохыг нотлох баримтаар тогтоосон байхыг шаарддаг.

Гэвч шүүхээс 2022 оны 05 сарын 11-ны өдрийн А/73 дугаар захирамжийг хүчингүй болгохдоо Дорнод аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газрын 2021 оны 06 сарын 03-ны өдрийн 2/7 дугаарт албан бичиг, 2014 оны 10 сарын 17-ны өдрийн Дорнод аймгийн мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн зөвлөмжийг тус тус үндэслэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх үүргээ удаа дараа зөрчсөн гэж дүгнэж байгаа нь хуулийг дээд шүүхийн тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн, 2022 оны захирамжид холбогдуулан нотлох баримт цуглуулах ажиллагаа хийгээгүй болохыг харуулна.

Нөгөөтэйгүүр Дорнод аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газрын 2021 оны 06 сарын 03-ны өдрийн 2/7 дугаарт албан бичиг, 2014 оны 10 сарын 17-ны өдрийн Дорнод аймгийн мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн зөвлөмж нь Дорнод аймгийн засаг даргын 2013 оны А/113 дугаар захирамжаар Соёмбо буудай ХХК-д газар олгосон захирамжийг хүчингүй болгохгүй байгаа эс үйлдэхгүйг хууль бус болохыг тогтоолгох шаардлагад хамааруулж цуглуулсан нотлох баримт бөгөөд 2022 оны 05 сарын 11-ны өдрийн "Эзэмшил газрыг нэгж талбар бүрээр хуваан эзэмшүүлэх тухай" А/73 дугаар захирамжид холбогдуулан захиргааны хэргийн шүүхээс нотлох баримт цуглуулах ямар ч ажиллагаа хийгээгүй болохыг дурдах нь зүйтэй.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Хянавал хэсэгт: *"Дээрхээс үзвэл байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх нь газар эзэмшигчийн үүрэг бөгөөд газар эзэмших эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө аль алинд нь нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэхээр хуульчилсан байх тул ..." хэмээн дүгнэсэн атлаа 2022 оны 05 сарын 11-ны өдрийн А/73 дугаар захирамжаар Соёмбо буудай ХХК газар эзэмших эрх авахдаа Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.7 дахь хэсэгт заасны дагуу газар эзэмших гэрээний хавсралт болгон ямар баримт өгснийг мэдэлгүйгээр, тухайн баримтыг цуглуулах ажиллагаа хийлгүйгээр, Газрын тухай хуулийг удаа дараа зөрчсөн гэж дүгнэх боломжгүй, буюу хууль болон гэрээг удаа дараа зөрчсөн нөхцөл байдлыг тогтоосон гэж үзэх боломжгүй юм. Иймд анхан болон давж заалдах шатны шүүх нотлогдон тогтоогдоогүй баримтаар хэргийг шийдвэрлэсэн, хуулийг УДШ-аас өөрөөр тайлбарласан байна.*

2.2 Улсын дээд шүүхийн 2023 оны 07 сарын 03-ны өдрийн "Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай" 30 дугаар тогтоолын 9 дэх хэсэгт "Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.5-д заасан "хэргийн оралогчдын маргаагүй асуудал" гэдэгт нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэл болон тэдгээрт холбогдох талуудын татгалзал, тайлбараар талуудын маргаж буй үйл баримтад хамаарахгүй асуудлууд, үйл баримтыг тогтоох, түүнчлэн, маргаан бүхий захиргааны шийдвэр хуульд нийцсэн эсэх, нэхэмжлэгчийн эрхийг зөрчсөн эсэхийг тогтоохтой хамааралгүй бусад нөхцөл байдлыг ойлгоно. Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн, эсхүл хуульд заасан тохиолдолд захиргааны байгууллагаас нэхэмжлэл гаргасан тохиолдолд нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй байгааг, түүнчлэн ямар хууль зөрчигдсөн, эсхүл нийтийн эрх зүйн ямар чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүйд хүрснийг шүүх тогтоохдоо нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэл болон тэдгээрт холбогдох талуудын татгалзал, тайлбарын хүрээнд дүгнэлт хийж, шийдвэр гаргана" гэж тайлбарласан байдаг.

Гэтэл Анхан шатны шүүхийн шийдвэрийн Үндэслэл нь хэсэгт: *"Нэхэмжлэгчээс Соёмбо буудай ХХК нь Химийн хортой бодис ашигласан, 3 жил дараалан 2016-2019 онд газартаа тариалалт хийгээгүй гэж маргасан ч, энэ нь 2022 оны 05 сарын 30-ны өдрийн Шинжээчийн дүгнэлт, мөн 2023 оны 07 сарын 03-ны өдрийн 04 дугаартай Шинжээчийн дүгнэлт, 2023 оны*

27 4

хийсэн Газрын төлөв байдал чанарын хянан баталгааны Хөрсний химийн ахуйн бусад бохирдол байхгүй дүгнэлтээр няцаагдаж байна. Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2, 40.1.4, 40.1.6-д заасан үндэслэл тогтоогдохгүй байна. Харин Газрын тухай хуулийн ... 40.1.2, 40.1.4, 31.4, 40.1.6-д заасан үндэслэл тогтоогдохгүй байна ..." хэмээн дүгнэсэн атлаа, мөн Үндэслэх хэсэгтээ "... Газрын тухай хуулийн 40.1.1 ... Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйл 7.2 дахь хэсэгт заасныг 2013, 2022 онд тус тус зөрчиж ... Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, 34.7 дахь хэсэгт заасныг зөрчсөн нь тогтоогдож байх тул Дорнод аймгийн Халхгол сумын Засаг даргын 2022 оны 05 сарын 11-ны өдрийн А/73 дугаар захирамжийг хүчингүй болгох нь зүйтэй гэж үзлээ" (шийдвэрийн 14,15 дугаар хуудас)" гэж дүгнэсэн. Харин Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хэргийг бүхэлд нь хянасан гэх болов ч энэ талаар дүгнэлт хийгээгүй.

Өөрөөр хэлбэл анхан болон давж заалдах шатны шүүхээс нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлага, үндэслэлийг "тогтоогдохгүй байна" хэмээн дүгнэсэн атлаа хэргийн оролцогчийн маргаагүй үндэслэлээр өөрсдөө шийдвэр гаргаж, хуулийг Улсын дээд шүүхийн тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн, хэргийн оролцогчийн мэтгэлцэх эрхийг ноцтой зөрчсөн үйлдэл юм.

Иймд дээрх шүүхийн шийдвэр, магадлал Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйл 106.5 дахь хэсгийг илтдэг зөрчсөн гэж өмгөөлөгчийн зүгээс үзэж байна.

§ **ГУРАВ: Хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой нөхцөл**
§ **байдлын тухайд:**

3.1 Захиргааны шүүхээс 2022 оны 05 сарын 11-ны өдрийн А/73 дугаар захирамжийг хүчингүй болгохдоо Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээг Соёмбо буудай ХХК нь хийлгэсэн эсэх, газар эзэмших эрх авч гэрээ байгуулахдаа ямар баримт хавсаргаж гэрээ байгуулсан эсэхийг тодруулалгүйгээр, талуудын мэтгэлцээгүй үндэслэлээр хэргийг шийдвэрлэсэн тул гуравдагч этгээдийн өмгөөлөгчийн зүгээс эерэг нөлөөлөл бүхий захиргааны актын хөөн хэлэлцэх хугацааны тухай давж заалдах гомдолд дурдсан болно. Учир нь анхан шатны шүүх хэрэг маргааныг нэгэнт хэлэлцэж шийдвэрлэсэн тул давж заалдах гомдол 2022 оны 05 сарын 11-ны өдрийн А/73 дугаар захирамжийн холбогдох баримтыг хавсаргах боломжгүй билээ.

Гэвч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалын Хянавал хэсгийн 6.7 дахь хэсэгт: "Дорнод аймгийн засаг даргын 2022 оны 05 сарын 11-ны өдрийн "Эзэмшил газрыг нэгж талбар бүрээр хуваан эзэлшүүлэх тухай" А/73 дугаар захирамжийг захиргааны байгууллага хүчингүй болгож байгаа тохиолдолд хуульд заасан 5 жилийн хугацааг баримтлах бөгөөд шүүхийн журмаар хүчингүй болгож байгаа энэ тохиолдолд хамаарахгүй" хэмээн дүгнэсэн нь үндэслэлгүй юм.

Аливаа эрх зүйн харилцаа нь төрийн эрх бүхий этгээдээр хамгаалуулах, шүүхэд мэдүүлэх, шаардах эрхээ хэрэгжүүлэх хөөн хэлэлцэх хугацаатай байдаг бөгөөд Захиргааны ерөнхий хуульд эерэг нөлөөлөл бүхий захиргааны актыг хүчингүй болгох хөөн хэлэлцэх хугацааг мөн хуулийн 48 дугаар зүйлд зохицуулж өгсөн байдаг. Өөрөөр хэлбэл хууль тогтоогчийн зүгээс эерэг нөлөөлөл бүхий захиргааны актыг хүчингүй болгох хөөн хэлэлцэх хугацааг 5 жил байхаар тогтоож өгсөн байхад шүүх тухайн хуулийг зөвхөн захиргааны байгууллага хэрэглэхэд 5 жил байх ёстой, шүүх хэрэглэж байгаа тохиолдолд хугацаа хамаарахгүй мэтээр тайлбарлаж байгаа нь хуулийг зохих журмын дагуу тайлбарлаж хэрэглээгүй гэж үзэхээр байна.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалын Хянавал хэсгийн 6.9 дахь хэсэгт: "Түүнчлэн дээрх засаг даргын захирамж Газрын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн болох нь тогтоогдож байх тул гуравдагч этгээдийн итгэл хамгаалагдахгүй" гэж дүгнэсэн нь үндэслэлгүй байна.

Учир нь манай компанийн зүгээс эрх бүхий этгээдийн эзэмших эрх олгосон газрын гэрчилгээг үндэслэн бүтэн 11 жилийн туршид зөвхөн газар тариалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэхүү хугацаанд бидэнд эзэмшүүлсэн тариалалтын талбайг зохих журмаар нь хэрэглэж, их хэмжээний хөрөнгө оруулалт хийж үйл ажиллагаа явуулсаар ирсэн тул Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл 4.2.8 дахь хэсэгт заасан “хууль ёсны итгэл хамгаалагдах” ёстой гэж өмгөөлөгчийн зүгээс үзэж байна. Түүнчлэн манай компанийн зүгээс газар тариалалтын үйл ажиллагаа явуулахдаа газрыг салхины элэгдэл, эвдрэлээс хамгаалах, тариалангийн газрын хөрсний үржил шимийг хамгаалах, сайжруулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлж байсан, мөн хөрсний механик бүрэлдэхүүн өөрчлөгдөх үр дагавар бий болох, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах холбогдох арга хэмжээ авч ажиллаж байсан болох нь хэрэгт авагдсан Шинжээчийн дүгнэлтээр тогтоогддог. (1 дүгээр хавтаст хэргийн 250 дугаар тал, 2 хавтаст хэргийн 8-11, 77-78 дугаар тал)

Мөн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйл 7.2 дахь хэсэгт заасан “... байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг ... төсөл хэрэгжүүлэхээс өмнө” гэх нөхцөл байдлыг эргэлзээгүй тогтоогүй, Засаг даргын 2022 оны 05 сарын 11-ны өдрийн “Эзэмшил газрыг нэгж талбар бүрээр хуваан эзэмшүүлэх тухай” А/73 дугаар захирамжийг Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.7 дахь хэсэгт заасан нөлөөллийн үнэлгээ хийж гэрээнд хавсаргасан эсэх баримтуудыг цуглуулах ажиллагаа хийгээгүй атлаа хууль зөрчсөн тул итгэл хамгаалагдахгүй хэмээн дүгнэж буй нь илтэд үндэслэлгүй байна.

Иймд дээр дурдсан нөхцөл байдлыг харгалзан үзэж шийдвэр, магадлал “Хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх” хуулийн зарчмыг хангаж чадаагүй байх тул Хэнтий аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 10 сарын 24-ны өдрийн 127/ШШ2024/0013 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 01 сарын 07-ны өдрийн 221/МА2025/0018 дугаар магадлалын нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн хэсгийг хүчингүй болгож өгнө үү.

ӨМГӨӨЛӨГЧ:

Г.Мөнхбуян

(Г.МӨНХБУЯН)

Утас: 99797898

